



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/006/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Аудитор Э.Нямсүрэн
Утас: 99629111
Цахим хаяг: nyamsurene@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangaiaudit.gov.mn

2026.02.25 № 109
танай _____-ны № _____-т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГАНХУЯГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Орон нутгийн өмчид бүртгэлтэй цөм сүргийн малыг бусдад түрээслүүлсэн орлогыг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйн улмаас жилийн эцэст 36,241.3 төгрөгийн авлага үүсгэсэн;
2. Дуусаагүй барилга байгууламж дансанд 6 жилийн өмнө бүртгэсэн 117.8 сая төгрөгийн ахуй үйлчилгээний барилгын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй;
3. Байгууллагын албан хаагчдад 2,057.1 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцон олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан;

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтуудыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 458,322.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 237,783.5 мянган төгрөгийг зарцуулж, 174,676.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн засаг даргад хүргүүлж 89.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	85,324,197.93	120,741,322.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	824,197.93	
335	Бусад авлага	84,500,000.00	120,741,322.00
3351	Байгууллагаас авах авлага	84,500,000.00	120,741,322.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,298,170,048.00	417,500.00
354	Хангамжийн материал		417,500.00
3541	Бичиг хэргийн материал		152,000.00
3542	Аж ахуйн материал		265,500.00
356	Мал амьтад	1,298,170,048.00	
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,383,494,245.93	121,158,822.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,594,967,393.50	8,976,094,268.35
392	Биет хөрөнгө	8,594,967,393.50	8,975,494,268.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,594,965,140.01	5,448,505,886.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-501,446,773.70	-643,930,818.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	461,988,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,458,222.27	-24,305,555.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,425,276,152.49	3,418,636,897.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,139,055,141.30	-1,419,152,016.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,433,786.13	32,583,219.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,639,849.26	-21,274,779.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,704,867,249.21	1,120,125,596.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-993,785,863.81	-897,210,273.22
39216	Дуусаагүй барилга, байгууламж	117,822,916.00	1,936,516,112.00
393	Биет бус хөрөнгө		600,000.00
39301	Програм хангамж	1,200,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,200,000.00	
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,594,967,393.50	8,976,094,268.35
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,978,461,639.43	9,097,253,090.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,500,000.00	90,654,652.26
413	Өглөг		6,154,652.26
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		4,980,000.00
4136	Бусад өглөг		1,174,652.26
41361	Байгууллагад төлөх өглөг		1,174,652.26
414	Урьдчилж орсон орлого	84,500,000.00	84,500,000.00
4144	Бусад урьдчилж орсон орлого	84,500,000.00	84,500,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	84,500,000.00	90,654,652.26
51	Засгийн газрын хувь оролцоо	9,893,961,639.43	9,006,598,438.09
512	Хуримтлагдсан үр дүн	9,801,703,167.47	8,914,339,966.13
5121	Өмнөх үеийн үр дүн	9,801,703,167.47	9,801,703,167.47
5122	Тайлант үеийн үр дүн		-887,363,201.34
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,258,471.96	92,258,471.96
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,893,961,639.43	9,006,598,438.09
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,978,461,639.43	9,097,253,090.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,362,720.00	412,459,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,155,920.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,155,920.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322,206,800.00	412,459,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,206,800.00	412,459,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,192,482,048.00	1,880,408,149.61
120	Нийтлэг татварын бус орлого	1,192,482,048.00	1,880,408,149.61
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	46,800,000.00	1,821,808,495.61
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,145,682,048.00	58,599,654.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,519,844,768.00	2,292,867,849.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,125,574,453.40	1,456,736,047.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,072,408,953.48	1,281,299,906.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,085,802.87	182,751,860.41
210101	Үндсэн цалин	110,792,162.91	103,477,542.61
210102	Нэмэгдэл	66,455,100.48	57,762,539.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,490,000.00	10,370,000.00
210104	Урамшуулал	15,348,539.48	11,141,778.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,787,913.28	24,398,341.04
210201	Тэтгэврийн даатгал	17,535,781.02	17,120,450.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,063,033.05	1,804,898.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,031,516.54	874,729.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,031,516.54	874,729.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,126,066.13	3,723,532.44
2104	Хангамж, бараа материалын зардал	15,161,356.00	52,757,654.00
210401	Бичиг хэрэг	4,924,766.00	2,135,510.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,636,590.00	6,793,144.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,826,600.00
210408	Бараа материал акталсны зардал		37,602,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,545,400.00	1,459,000.00
210604	Урсгал засвар	4,545,400.00	1,459,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	15,030,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	15,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,278,650.00	440,483.00

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,190,920.00	288,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,730.00	112,483.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	809,049,831.33	1,004,462,567.71
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	809,049,831.33	1,004,462,567.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,165,499.92	175,436,141.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,339,000.00	760,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,342,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,997,000.00	760,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,826,499.92	174,676,141.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,826,499.92	174,676,141.74
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,125,574,453.40	1,456,736,047.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	394,270,314.60	836,131,801.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,203,253,108.49	1,723,495,003.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,203,253,108.49	440,569,023.05
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,282,925,980.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,203,253,108.49	-1,723,495,003.05
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,808,982,793.89	-887,363,201.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	327,362,720.00	412,459,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,362,720.00	412,459,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,155,920.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,155,920.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322,206,800.00	412,459,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,206,800.00	412,459,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	317,348,820.00	408,109,730.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,348,820.00	408,109,730.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,183,320.08	232,673,588.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,406,500.80	182,224,298.15
210101	Үндсэн цалин	111,112,860.84	102,949,980.35
210102	Нэмэгдэл	66,455,100.48	57,762,539.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,490,000.00	10,370,000.00
210104	Урамшуулал	15,348,539.48	11,141,778.00

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,787,913.28	23,574,143.11
210201	Тэтгэврийн даатгал	17,535,781.02	16,296,252.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,063,033.05	1,804,898.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,031,516.54	874,729.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,031,516.54	874,729.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,126,066.13	3,723,532.44
2104	Хангамж, бараа материалын зардал	14,894,856.00	14,126,554.00
210401	Бичиг хэрэг	4,658,266.00	1,844,810.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,636,590.00	7,018,644.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,863,100.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,985,400.00	1,459,000.00
210604	Урсгал засвар	4,985,400.00	1,459,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	10,050,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	10,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,608,650.00	1,239,593.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,520,920.00	1,188,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,730.00	11,593.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,165,499.92	175,436,141.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,339,000.00	760,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,342,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,997,000.00	760,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,826,499.92	174,676,141.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,826,499.92	174,676,141.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,013,900.00	4,349,970.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,013,900.00	4,349,970.00
	Дотоод эх үүсвэрээр	10,013,900.00	4,349,970.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,013,900.00	4,349,970.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,013,900.00	-4,349,970.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	14,610,685,961.36	14,702,944,433.32
2	Тайлант үеийн үр дүн		-4,808,982,793.89	-4,808,982,793.89
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	9,801,703,167.47	9,893,961,639.43
4	Тайлант үеийн үр дүн		-887,363,201.34	-887,363,201.34
5	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	8,914,339,966.13	9,006,598,438.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
132001	Орон нутгийн төсвөөс	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,122,500.00	237,023,558.26	215,098,941.74	52.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,186,200.00	182,224,298.15	108,961,901.85	62.6
210101	Үндсэн цалин	128,630,000.00	102,949,980.35	25,680,019.65	80
210102	Нэмэгдэл	126,366,000.00	57,762,539.80	68,603,460.20	45.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,190,200.00	10,370,000.00	7,820,200.00	57
210104	Урамшуулал	18,000,000.00	11,141,778.00	6,858,222.00	61.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,399,200.00	23,574,143.11	12,825,056.89	64.8
210201	Тэтгэврийн даатгал	24,751,800.00	16,296,252.85	8,455,547.15	65.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,911,900.00	1,804,898.90	1,107,001.10	62
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,455,900.00	874,729.46	581,170.54	60.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,455,900.00	874,729.46	581,170.54	60.1
210205	Эрүүл мэндийн даатгал	5,823,700.00	3,723,532.44	2,100,167.56	63.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,970,000.00		54,970,000.00	
210301	Гэрэл, цахилгаан	9,400,000.00		9,400,000.00	
210302	Түлш, халаалт	40,770,000.00		40,770,000.00	
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00		4,800,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	24,830,700.00	14,126,554.00	10,704,146.00	56.9
210401	Бичиг хэрэг	6,130,700.00	1,844,810.00	4,285,890.00	30.1
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	3,400,000.00	800,000.00	81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,400,000.00	7,018,644.00	1,381,356.00	83.6

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	600,000.00		600,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	1,863,100.00	3,636,900.00	33.9
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,000,000.00	5,808,970.00	20,191,030.00	22.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	4,349,970.00	7,650,030.00	36.3
210602	Тавилга	4,000,000.00		4,000,000.00	
210604	Урсгал засвар	10,000,000.00	1,459,000.00	8,541,000.00	14.6
2107	Томилолт, зочны зардал	12,000,000.00	10,050,000.00	1,950,000.00	83.8
210702	Дотоод албан томилолт	12,000,000.00	10,050,000.00	1,950,000.00	83.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,736,400.00	1,239,593.00	5,496,807.00	18.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,400,000.00	1,188,000.00	3,212,000.00	27
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00		100,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	346,400.00	11,593.00	334,807.00	3.35
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	190,000.00		190,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,700,000.00	40,000.00	1,660,000.00	2.35
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,200,000.00	760,000.00	5,440,000.00	12.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,200,000.00	760,000.00	5,440,000.00	12.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,200,000.00	760,000.00	5,440,000.00	12.3
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	458,322,500.00	237,783,558.26	220,538,941.74	51.9
3	Төсвийн байгууллага	1	1		100
6	Удирдах ажилтан	1		1	
7	Гүйцэтгэх ажилтан	5	4	1	80
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	4	2	66.7
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6	4	2	66.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,687.1 мянган төгрөгийн зөрчил^[1] илэрснээс, 1 зөвлөмж, 2,057.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 630.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 38,928.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32,053.6 мянган төгрөгөөр бага тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын албан хаагчдад 2,057.1 мянган төгрөгийн илүү цагийг сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн тооцон олгосон байна

Энэ нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3-т "илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Орон нутгийн өмчид бүртгэлтэй цөм сүргийн малыг бусдад түрээслүүлсэн орлогыг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйн улмаас жилийн эцэст 36,241.3 төгрөгийн авлага үүсгэсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4- т Энэ хуулийн 5.1.3-т заасан "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2.2. Тайлан онд өмнөх оны баримтаар буюу өр төлбөр үүсгэж бүртгээгүй томилолтын зардалд 630.0 мянган төгрөгийг олгосон байна..

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.3-т "бүх өр төлбөр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Тайлант онд дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн олон жилийн насжилттай 117.8 сая төгрөгийн ахуй үйлчилгээний барилга байгууламж холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.3.6-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн олон жилийн насжилттай 117.8 сая төгрөгийн ахуй үйлчилгээний барилга байгууламж холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	-					1	-
Байгууллагын албан хаагчдад 2,057.1 мянган төгрөгийн илүү цагийг сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн тооцон олгосон байна	1	2,057.1	1	2,057.1				
Тайлан онд 2024 оны томилолттой холбоотой 630.0 мянган төгрөгийг өмнөх онд өр төлбөр үүсгээгүй зарлцуулсан байна	1	630.0			1	630.0		
Орон нутгийн өмчид бүртгэлтэй цөм сүргийн малыг бусдад түрээслүүлсэн орлогыг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйн улмаас жилийн эцэст 36,241.3 төгрөгийн авлага үүсгэсэн	1	36,241.3			1	36,241.3		
Нийт	4	38,928.4	1	2,057.1	2	36,871.3	1	-